



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/116

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 17 дугаар зөвлөмжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газарт 2019 онд хэрэглэгдэх шатахуун, шатах тослох материалыг 14355190 (арван дөрвөн сая гурван зуун тавин таван мянга нэг зуун ер) төгрөгөөр “Шунхлай трейдинг” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулж, шатах тослох материал нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) -т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүч (А.Саруулбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100264